

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК-НЫ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025.04.29

Улаанбаатар хот

“Э-Транс ложистикс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 сарын 29-ний өдөр “ БиДиСек ҮЦК “ ХК-ны хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах программаар 10 цагаас эхлэв.

Тооллогын комисс ирцээ танилцуулав. Тооллогын комиссын гишүүн Г.Энхжин ХЭХ-ыг зохион байгуулах системээс ирүүлсэн ирцийн мэдээллийн дагуу гаргасан Тооллогын комиссын ирцийн тогтоолыг уншиж танилцуулав.

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 45,310,870 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий 46,200,000 ширхэг хувьцааны 98.08 хувь болж байгааг хуралд оролцогчдод болон хурлын даргад мэдээлсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь хэсэг, “Э-Транс ложистикс” ХК-ийн Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.14 дэх хэсгийг тус тус үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 98.08 хувийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Хурлын дарга Э.Батболд хурлын дэгийг танилцуулж хурлыг эхлэв.

Хэлэлцэх асуудал, дэгийг танилцуулав.

Хурлын дэгийн дагуу Компанийн санхүүгийн тайлан түүнд хийсэн хараат бус аудиторын дүгнэлтийг компанийн тооцооны нягтлан бодогч Б.Золзаяа танилцуулав.

Тооцооны нягтлан бодогч Б.Золзаяа: Э-Транс ложистикс ХК-ны 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг танилцуулъя. Эхлээд зөрчилгүй дүгнэлтийг танилцуулна. Э-Транс ложистикс ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгоод санхүүгийн тайлан орлогын дэлгэрэнгүй тайлан мөнгөн гүйлгээний тайланд тус аудитын компаниас аудитын шалгалт хийсэн. Тус дүгнэлтээр манай компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналийн олон улсын стандартын дагуу шударгаар тайлангаа бэлтгэсэн байна гэж дүгнэсэн. Санхүү байдлын тайлангаар эргэлтийн хөрөнгийн нийт дүн өмнөх онтой харьцуулахад 946,751,177.15 төгрөг байсан бол 4,297,803,527.83 төгрөг болж 3,3 тэрбум төгрөгөөр өссөн, эргэлтийн бус хөрөнгийн дүн өмнөх онд 4,6 тэрбум төгрөг байсан бол энэ онд 4,9 тэрбум төгрөг болж 239 сая төгрөгөөр өссөн, өр төлбөрийн хувьд богино хугацаат өр төлбөрийн дүн 101 сая төгрөг байсан бол 2024 оны эцсийн байдлаар 148 сая төгрөг болж өссөн, урт хугацаат өр төлбөрийн дүн өмнөх онд урт хугацаат өр төлбөр байгаагүй бөгөөд 2024 оны 12 сарын 31-ний байдлаар урт хугацаат өр төлбөр 3,2 тэрбум төгрөг болон өссөн, эздийн өмчийн дүн нийт 5,5 тэрбум төгрөг байснаас 5,9 тэрбум төгрөг болж

өссөн байгаа ба нийт балансийн маань дүн 9,2 тэрбум төгрөг байна. Орлогын дэлгэнгүй тайлангаар борлуулалтын нийт орлого 2023 оны 12 сарын 31-ний байдлаар 2,4 тэрбум төгрөг байсан ба 2024 оны жилийн эцсийн байдлаар 3,6 тэрбум төгрөг болж өссөн, түрээсийн орлого 53 сая байсан бол 2024 онд 82,6 сая төгрөг, дансны үлдэгдэлээс бодсон хүүгийн орлого маань 1 сая төгрөг байсан бол 2024 онд 4,7 сая төгрөг, борлуулалт маркетингийн зардал 1,8 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 2,8 тэрбум төгрөг, санхүүгийн зардал нь өмнөх онд үүсээгүй 2024 онд 48,2 сая төгрөг, бусад зардал 26,7 сая төгрөг байсан бол 2024 онд 107,8 сая төгрөг болж өссөн байна. За ингээд татвар төлөхийн өмнөх ашиг 635,1 сая төгрөг байсан бол 2024 оны жилийн эцсээр 767,9 сая төгрөг болж өссөн, татварын дараах ашиг маань 568,9 төгрөг байсан бол 2024 оны байдлаар 680,3 сая төгрөг болж өссөн байна. Өмчийн өөрчлөлтийн тайлан дээр өмнөх онд эздийн өмчийн нийт дүн маань 5,5 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 5,9 тэрбум төгрөг болж өссөн хуримтлагдсан ашиг өмнөх онтой харьцуулахад 400-гаад сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн гүйлгээний тайлангаас үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн 2023 онд 493,7 сая төгрөг байсан бол 2024 онд 819,7 сая төгрөг болж өссөн, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн 2023 оны жилийн эцсээр -130,7 сая төгрөг байсан бол 2024 оны жилийн эцсээр 1,3 тэрбум төгрөг болж өссөн эндээс бүх цэвэр мөнгөн гүйлгээний дүн 269,6 сая төгрөг байсан бол 2024 онд 1,1 тэрбум төгрөг болж өссөн байна. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 571,5 сая төгрөг байсан бол 2024 оны жилийн эцсээр 1,6 тэрбум төгрөг болж өссөн байна. Компанийн талаарх мэдээллийн хувьд Э-Транс ХХК нь 2023 онд 2,310,000,000 төгрөгийн дүн бүхий 50 хувийн хувьцаа эзэмшиж байсан бөгөөд 2024 оны байдлаар 4,524,445,400 төгрөгийн дүн бүхий 97,9 хувийн хувьцааг эзэмшиж байгаа бөгөөд тайлант онд хувьцаа эзэмшигчдийн тоонд материаллаг дүнтэй өөрчлөлт орж, компанийн нийт хувьцааны 97,9 хувийг Э-Транс ХХК эзэмших болсон. Нийт 3 иргэний 1243 ширхэг тусгаарлагдсан хувьцаа байна. Компанийн үйл ажиллагааны орчин хууль зүйн орчинд үйл ажиллагаанд нөлөөлөхүйц өөрчлөлт ороогүй. Гаалийн хяналтын талбайг өргөтгөх зориулалтаар шинээр 1 иргэнээс 460 сая төгрөгөөр 3440м² талбайг худалдан авч бэлтгэл ажлыг хангаж байна. Кассан дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 2023 оны жилийн эцэст 550,8 сая төгрөг байсан бол 2024 оны 12 сарын 31-ний байдлаар 1,5 тэрбум төгрөг болж өссөн. Энэ бол гадна худалдаж аваагүй байгаа газрын бусад хийгдэх ажлуудын төлбөрүүд кассан дахь бэлэн мөнгөөр хуримтлагдаж байгаа болно. Урьдчилж төлсөн зардлын хувьд худалдан авалтын урьдчилгаа 246,9 сая төгрөг байсан бол 2024 онд 837,8 сая төгрөг болж өссөн. Энэ бол газар худалдан авсантай холбоотой тухайн газраа хашаажуулах зорилгоор худалдаж авсан төлбөр болон бусад төлбөрүүд багтсан болно. 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар компани нь нийт 1,988,328,466.72 төгрөгийн өртөгтэй өөрийн эзэмшлийн газар, нэг цэгийн үйлчилгээний барилгыг ХХБ-ны зээлийн барьцаанд барьцаалсан. Ногдол ашигтай холбоотой ажил үйлчилгээний хувьд нийт 277,4 сая төгрөгийн ногдол ашгийг тараахаар зарласан бөгөөд үүнээс ХХОАТ-ийн 5хувийг хасан нийт 254,5 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 сарын 11-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор Э-Транс ложистикс ХК-ийн үйл ажиллагааг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг 2025 онд хийхээр төлөвлөсөн тул 2024 оны үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Хурлын дарга Э.Батболд: Дараагийн асуудал болох компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлагналыг гүйцэтгэх захирал Ч.Энхболд томилолтоор яваа тул түүнийг төлөөлөн С.Ганбат танилцуулна.

Дотоод ажил, хяналт хариуцсан ажилтан С.Ганбат: 2024 онд тус компанийн үйл ажиллагаа улс орны эдийн засгийн нөхцөл байдал сайжирч байгааг даган өмнөх оны мөн үеийнхээс сайжирч нэлээдгүй ажил үйлчилгээтэй, ашиг орлого нэмэгдсэн байдалтай байсан. Компанийн үндсэн үйл ажиллагаа болох төмөр замаар шилжүүлэн ачих үйл ажиллагаа зорилтот түвшинд хүрээгүй боловч шилжүүлэн ачилтын орлого өмнөх оны мөн үеийнхээс өссөн үзүүлэлттэй байна. Гаалийн хяналтын бүсэд нэвтэрч гаалийн бүрдүүлэлт хийсэн тээврийн хэрэгсэл өмнөх оныхоос нэлээдгүй өссөн нь гаалийн хяналтын бүс дэх өндөрлөсөн тавцанг ашиглан чингэлгээр орж ирсэн автомашиныг буулгах ажлыг гаалийн байгууллагатай хамтран зохион байгуулсны үр дүн гэж харж байна. Энэ ажлын хүрээнд 3823 тээврийн хэрэгслээр оруулж ирсэн чингэлгийг задалж 15,200 орчим машиныг буулгах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Гаалийн хяналтын бүсэд өмнөх жилд 27039 тээврийн хэрэгсэл нэвтэрч байсан бол 2024 онд 38526 тээврийн хэрэгсэл нэвтэрч гаалийн хяналт шалгалтанд хамрагдсан нь тус гаалийн хяналтын бүсэд орж ирж байгаагүй тоо хэмжээ юм. Орлогын өсөлт бууралтыг сая нягтлан нэлээдгүй тодорхой ярьсан тул ингээд харуулчихъя. Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоог өмнөх жилийнхтэй жишиж харуулсан байгаа сар сараар нь харуулсан үзүүлэлтийг харуулж байна. Үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачилтын 2023 оны байдлаар 260 вагон ачааг шилжүүлэн ачиж байсан бол 2024 онд 217 вагон ачилт яльгүй буурсан байгаа. Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлтийн хувьд хөрөнгийн өсөлтийн хурд 0,1 хувьтай, эргэлийн хөрөнгийн хувийн жин өмнөх оныхоос 2,8 дахин өссөн, нийт хөрөнгийн 47,14 хувийг эзэлж байна. Санхүүгийн байдлын үнэлгээгээр ажлын капитал 4,1 тэрбум төгрөг байгаа ба өмнөх оныхоос 3,3 тэрбм төгрөгөөр өссөн. Ажлын капитал сайн ба ямар нэгэн өр төлбөрийн дарамтын эрсдэл бага байна. Ажлын капиталын оролцоо 0,95 байх ба өр төлбөрийн дарамтанд орох эрсдэл бага, эргэлтийн харьцаа 23,4 эргэлтийн хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрийг барагдуулах чадвар сайн, өрийн харьцаа 2,77 байна. 2024 оны 10 сарын 16-ны өдөр тус компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Э-Транс ХХК-ийн хувьцаа эзэмшил 75 хувийг давсан тул 2024 оны 11 сарын 13-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаар Компанийн тухай хуулийн 54.4 дэх заалтийг үндэслэн бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг хурлаар Э-Транс ХХК-нд хувьцаагаа худалдан авах зөвшөөрлийг олгож, хувьцаагаа эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг 118.08 төгрөгөөр, хувьцаагаа худалдан авах саналын эхлэх өдрийг 2024 оны 11 сарын 18-ны өдрөөр, санал дуусах хугацааг 2024 оны 12 сарын 19-ний өдрийг дуустал байхаар тогтоосон. Энэхүү шийдвэрийн дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон Э-Транс ХХК-тай гурвалсан гэрээ байгуулан хувьцаагаа худалдах хүсэлт ирүүлсэн 3 хувьцаа эзэмшигчийн 66,414 ширхэг хувьцааг худалдан авч хувьцааны төлбөрийг шилжүүлүүлсэн байна. Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээллийг сая манай нягтлан тодорхой ярьсан байгаа болно. Ингээд үйл ажиллагааны тайлантай холбоотой асуудал дууссан байна.

Хурлын дарга Э.Батболд: Дараагийн асуудал руугаа оръё. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг уншиж танилцуулъя. Э-Транс ложистикс ХК-ны 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлагналд дурдсанаар тус компани нь санхүүгийн жилд 631,807,705.27 төгрөгийн үйл ажиллагааны орлоготой ажиллаж өмнөх жилийнхээс тодорхой хэмжээгээр өссөн, нэлээдгүй үр ашигтай ажилласан байна. 2024 оны үйл ажиллагаанд үнэлэлт өгөн компанийн үндсэн үйл ажиллагаа болох төмөр замаар ачаа, бараа шилжүүлэн ачих үйл ажиллагаанд голлох байр суурь эзлэх болсон төмөр хийцийн шилжүүлэн ачилтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд төмөр хийцийн гаалийн бүрдүүлэлтийг өөрийн хяналтын бүсэд хуваарилуулан шилжүүлэн ачилтыг нэг дор зохион байгуулах боломжийг судлан хэрэгжүүлэхээр үүрэг өгөгдсөн боловч энэхүү чиглэлд хяналт тавьж байгаа гаалийн байгууллагаас баталсан хуваарийнхаа дагуу ачаа барааг хуваарилах шаардлагатай гэсний үүднээс энэхүү ажил амжилтгүй болжээ. Гэхдээ өмнөх жилүүдэд гэрээ байгуулсан зарим аж ахуйн нэгжүүд гэрээний үндсэн дээр тус гаалийн хяналтын бүсэд хяналт шалгалтаа хийлгэн вагонд шилжүүлэн ачилт хийсэн ба энэ онд 215 вагон шилжүүлэн ачжээ. Шилжүүлэн ачилтын үйл ажиллагааг хэвийн явуулахад гол бэрхшээлтэй байгаа зүйл нь вагон хуваарилах асуудал хэвээр байгааг үйл ажиллагааны тайланд дурдсан байна. Үндсэн үйл ажиллагаа доголдолтой байгаа боловч гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр гаалийн байгууллагатай хамтран ажилласны үр дүнд компанийн ачаа бараа шалгах зориулалт бүхий өндөрлөсөн тавцанг ашиглан тээврийн хэрэгсэл дээр ачигдаж ирсэн чингэлгийг задлаж буулгах ажлыг хийж хэрэгжүүлснээр тус гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл 38,526 болж өссөн бөгөөд гарах хуудасны орлого 1,628,064,156 төгрөг болж нэмэгдсэн байна. Өндөрлөсөн тавцан ашиглаж чингэлэг задалж буулгах үйлчилгээг өмнөх жилүүдэд туршиж байсныг ажил хэрэг болгон үйлчилгээг нэмэгдүүлснээр 2024 онд 3826 чингэлэг задалж 15,300 орчим тээврийн хэрэгслийг буулган үйлчлүүлэгч нарт нь ямар нэгэн асуудалгүй хүлээлгэн өгсөн нь үйлчлүүлэгч болон гаалийн байгууллагад үнэлэгдэхүйц ажил болж цаашид үргэлжлүүлэн хийгдэхээр төлөвлөгджээ. Гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа ийнхүү жил тутам нэмэгдэж байгаагаас шалтгаалан гаалийн хяналтын бүсийн зай талбайн багтаамжийг нэмэх шаардлага гарсныг холбогдох иргэн, төр захиргааны байгууллагатай хамтран шийдвэрлэхээр ажиллаж эхний ээлжид хувь иргэнд байсан газрыг худалдан авч үлдсэн газрыг авах талаар ажил зохион байгуулж байгаа нь дүгнэлтэд дурдахуйц ажил болсон байна. Гүйцэтгэх удирдлагаас 2024 оны бизнес төлөвлөгөөнд заагдсан гаалийн хяналтын бүсийг цахимжуулах ажлыг Монгол улсын Ерөнхий сайдаас гаалийн байгууллага, боомтын захиргаанд өгөгдсөн үүрэгтэй уялдуулан ухаалаг орц гарцын төхөөрөмжийг худалдан авах ажилд 24 сая төгрөгийг зарцуулсан байх бөгөөд цаашид энэхүү ухаалаг төхөөрөмжийн программ хангамжийг өөрийн үйл ажиллагаа болон гаалийн байгууллагатай холбох ажлыг хийж дуусгахаар ажиллаж байгаатай танилцсан бөгөөд энэ нь үйл ажиллагаагаа хөнгөвчилсөн үйлчлүүлэгч иргэдэд хүрсэн ажил болжээ. Гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа ингэж өргөжихийн хэрээр гаалийн хяналтын бүсэд ачаа бараа хадгалсан үйлчилгээ болон бусад үйлчилгээ дагаж өссөн байх бөгөөд бусад орлого өмнөх оны мөн үеийнхээс 1,6 дахин өсөж 1,533,569.4 төгрөгийн ашиг олсон байна. Өмнөх жилүүдэд гаалийн нэг цэгийн үйлчилгээний танхим болон 2 давхрын гаалийн байцаагч нарын танхим

бусад өрөө тасалгааг үе шаттайгаар засварлаж дуусгасан байх бөгөөд 2024 онд төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 3 давхрын өрөөнүүдийн засварын ажлыг хийж гүйцэтгэн нийт 117 сая төгрөгийн зардал гаргасан байна. Компани нь 2024 онд үйл ажиллагааг өргөтгөж ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилгоор компанийн барилгын ойролцоох нийтийн эзэмшлийн газрыг худалдан авах, засварлах, "Э-транс ложистикс" ХК-ийн хувьцааг худалдан авахаар зорилгоор Худалдаа, хөгжлийн банкнаас 3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл, шинээр тээврийн хэрэгсэл худалдан авахад зориулж 143 сая төгрөгийн зээл зэргийг авсан байх бөгөөд зээлийн зарцуулалт, эргэн төлөлт хэвийн байна. Цаашид зээлийн эргэн төлөлт, зарцуулалтад онцгой анхаарал тавихыг гүйцэтгэх удирдлагад даалгалаа. Ажилчдын ажиллах идэвх сонирхлыг дэмжих, ажлын бүтээмжийг сайжруулах, урамшуулах үүднээс нийт ажилчдаа БНХАУ-ын Хайнань мужийн Саньяа амралт жуулчлалын бүс, Өвөрмонголын Хөх хотуудаар 8 хоногийн аялал хийж амруулсан нь сайшаалтай ажил болсон байна. 2025 онд өмнөх оныхоо ажлыг баталгаажуулан үр ашгаа бууруулахгүй байхад анхаарч ажиллахын зэрэгцээ дараах ажлуудад анхаарлаа хандуулж ажиллана уу (Компанийн эзэмшиж болох газрыг худалдан авах, тэдгээрийг тохижуулах ажилд анхаарч ажиллах, Шилжүүлэн ачилтыг нэмэгдүүлэх, өөр төрлийн үйлчилгээг салбар замаа ашиглан зохион байгуулах боломжийг судлах, Зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд анхаарах, "БиДиСек ҮЦК" ХК-тай хамтран хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох ажлыг зохион байгуулах.)

За ингээд ТУЗ-ийн дүгнэлтийг уншиж танилцууллаа. Араагийн асуудал Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг С.Ганбат танилцуулна.

Дотоод ажил, хяналт хариуцсан ажилтан С.Ганбат: 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулъя. 2025 онд нийт 4 бүлэг, 9 хэсэг, 35 ажил хийхээр төлөвлөсөн Үүнээс гол гол хийгдэх ажлуудыг танилцуулъя. Ерөнхий сайдын албан даалгаврын хүрээнд гаалийн хяналтын бүс баталгаат агуулахад нэвтрэх тээврийн хэрэгслийг хянах ухаалаг орц гарцын ажлыг хийж дуусгахаар төлөвлөсөн. Мөн офиссын үүдний машины ил зогсоолын талбайг асфальтлах, түүний хашаа, орох гарах хэсгийн хаалтыг хий гүйцэтгэх гэх мэт ажлуудыг хийхээр төлөвлөсөн. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой ажлын хувьд төмөр замаар шилжүүлэн ачих үйл ажиллагааг сайжруулах, төмөр замтай байгуулах гэрээ, хэлцлүүдийг байгуулах, хугацаа дуусмагц сунгах, гэрээний дүнг хэлэлцэх, ачилтын төлөвлөгөөний дагуу ачааг ачих боломжийг судлан үйлчлүүлэгч татах ажлыг оновтой хэлбэрээр зохион байгуулах, вагон ашиглалтын хугацааг багасгах, пүүлэгч нарын ажлын идэвх санаачилгыг дээшлүүлэх, тэднийг байнгын удирдлагаар хангах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Мөн гаалийн хяналтын бүс болон баталгаат агуулахын өнгө үзэмж эмх цэгцийг байнга шалгаж шаардлагатай ажлуудыг танилцуулан хийж ажиллах, гаалийн баталгаат агуулахын урсгал засварын ажил хийгдэхтэй холбоотой ажлыг төлөвлөх, гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн, баталгаат агуулахад хадгалагдаж байгаа тээврийн хэрэгсэл, ачаа барааны тайланг сар, улирал, жилээр гарган холбогдох газар, компанийн эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж байх зэрэг ажлыг хийхээр гаалийн хяналтын бүсийн эрхлэгчид хариуцуулсан байна. Мөн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн чиглэлээр хэд хэдэн ажил хийхээр төлөвлөжээ. Үйлчилгээний нэр төрлийг олшруулахтай холбоотой техник технологийн шинэчлэл хийх боломж, хөрөнгийн судалгааг хийж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах ажлыг гүйцэтгэх захирал болбон ерөнхий

нягтлан бодогчид хариуцуулсан байна. Нийгмийн хамгааллын чиглэлээр ажилчдыг компанид тогтвор суурьшилтай, идэвхитэй ажиллахад нөлөөлөхүйц компанийн дотоод журамд заагдсан нийгмийн хамгаалалын тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэх, шинээр хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудын хүрээнд хийгдэх ногоон байгууламжийн ажлуудыг хийж гүйцэтгэх, үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран нийгмийн хамгаалалын тодорхой ажлыг хийж гүйцэтгэх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөжээ. Төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн хурлын чиглэлээр компанийн төлөөлөн удирдах зөвлөл, зөвлөлийн дэргэдэх хорооны хуралд бэлтгэх, гишүүдэд шаардлагатай мэдээллүүдийг цаг тухай бүрт хүргэх, компанийн жилийн ба хагас жилийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг бусад албадаас ирүүлсэн саналын дагуу гаргаж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулах, компанийн засаглалын бодлогыг хэрэгжүүлж нийтэд ил болгох мэдээллүүдийг компанийн албан ёсны вэб хуудас, хөрөнгийн бирж, компанийн засаглалын сайтуудад тухай бүр тавьж хувьцаа эзэмшигч нарыг компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр бүрэн хангах, хувьцаа эзэмшигчдийн хуралд шаардлагатай бичиг баримтыг цаг тухайд нь бэлэн болгох, хурал хуралдах ажлыг хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэгч компанитай хамтран зохион байгуулах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөжээ. Төлөвлөгөөнөөс танилцуулж дууслаа.

Хурлын дарга Э.Батболд: Дараагийн асуудал руугаа оръё. ТУЗ-ийн 2025 оны цалин урамшууллын төсвийг танилцуулъя.

ТУЗ-ийн гишүүд цалингүй ажиллаж байгаа. ТУЗ-ийн нарийн бичгийн цалин 792,000 төгрөгөөр 4 улиралд 3,168,000 төгрөг, Зөвлөх үйлчилгээний хөлс 3,000,00 төгрөг, ТУЗ-ийн хурлын зардал 100,000 төгрөг, бичиг хэргийн зардал 1,000,000 төгрөг, Бусад зардал 500,000 төгрөг гээд нийт 7,768,000 төгрөгийн зардал гаргахаар төсөвлөсөн байна. Асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Дараагийн асуудал ТУЗ-д нэр дэвшиж байгаа нэр дэвшигч нарыг танилцуулая. Чулууны Энхболд Э-Транс ХХК-ны ерөнхий захирал одоо Э-Транс ложистикс ХК-ны гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа хуучин гишүүн байна, дараагийн нэр дэвшигч бол улиран сонгогдож байгаа Амарсанаагийн Бат-Орших 2024 оноос эхлэн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байгаа, дараагийн нэр дэвшигч нь миний бие байна энэ жил мөн улиран сонгогдож байгаа, дараагийн нэр дэвшигч нь Эрдэнэбаатарын Ариунтуяа нэр дэвшиж байгаа, дараагийн нэр дэвшигч нь Энхболдын Уянга, мөн ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшиж байгаа Амарсанаагийн Гэрэлцогтыг танилцуулъя. 1988 онд төрсөн, ШУТИС-ийг уул уурхайн ашиглалтын инженерээр төгссөн, Э-Транс ХХК-нд уулын мастераар ажиллаж байсан, одоо Баянцемент ХХК-нд уулын инженерээр ажиллаж байгаа ийм хүн байна. Хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа Жаргалсайханы Энхтулга улиран сонгогдохоор нэр дэвшиж байгаа. Хараат бус гишүүнд шинээр нэр дэвшиж байгаа Шатарын Мөнхбаатарыг танилцуулъя. 1996 онд төрсөн. Эрдэм их дээд сругуулийг барилгын инженерээр төгссөн, МАК-ийн цементийн үйлдвэр, Ховд-Эко цементийн үйлдвэрт ажиллаж байсан. Одоо Баянцемент ХХК-ны шохойн үйлдвэрт үйлдвэрийн дарга ажилтай ийм хүн байна. Дараагийн нэр дэвшигч нь Чулуунбаатарын Оргил нь улируулан сонгогдохоор нэр дэвшиж байна. За эдгээр хүмүүсийг ТУЗ-д нэр дэвшүүлж байгаа юм байна.

Дараагийн асуудлыг танилцуулая. Энэ зүгээр танилцуулах асуудал тул уншаад танилцуулъя. 1. "Э-Транс Ложистикс" ХК-ны үйл ажиллагааг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник тоног төхөөрөмж шинэчлэх ажлыг 2025 онд хийхээр төлөвлөсөн тул 2024 оны үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай. 2. Ногдол ашиг хуваарилахгүй байх үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Гүйцэтгэх захирал / Ч. Энхболд /-д үүрэг болгосугай гэсэн тогтоолыг танилцуулж байна.

За Хувьцаа эзэмшигчдийн хурлаар гарах шийдвэрийн төслийг уншиж танилцуулъя. / Шийдвэрийн төслийг уншиж танилцуулав /

За ингээд өнөөдрийн хурлаар хэлэлцэх, танилцуулах асуудал дуусаж байна. Асууж тодруулах зүйлтэй хүмүүс байна уу? За байхгүй бол санал хураалт явагдаад дүнгээ танилцуулах хүртэл микрофоноо хаачиж болно.

Тооллогын комиссын гишүүн Г.Энхжин: Ирцэнд орсон хувьцаа эзэмшигч нар саналаа өгч дууссан тул шийдвэрээ уншиж танилцуулая. Э-Транс ложистикс ХК -ийн саналын эрхтэй нийт 46,200,000 ширхэг хувьцаанаас 98,08 хувь буюу 45,310,870 ширхэг хувьцаа эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувь буюу 45,310,870 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99,99% хувь зөвшөөрсөн, 0% хувь татгалзсан, 0,000004% / 1,000,000-ний 4/ хувь түдгэлзсэн байна.

2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэн батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувь буюу 45,310,870 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99,99% хувь зөвшөөрсөн, 0% хувь татгалзсан, 0,000004% / 1,000,000-ний 4/ хувь түдгэлзсэн байна.

3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувь буюу 45,310,870 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99,99% хувь зөвшөөрсөн, 0% хувь татгалзсан, 0,000004% / 1,000,000-ний 4/ хувь түдгэлзсэн байна.

4. Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувь буюу 45,310,870 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99,99% хувь зөвшөөрсөн, 0% хувь татгалзсан, 0,000004% / 1,000,000-ний 4/ хувь түдгэлзсэн байна.

5. ТУЗ-ийн 2025 оны цалин урамшууллын төсөв батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувь буюу 45,310,870 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99,99% хувь зөвшөөрсөн, 0% хувь татгалзсан, 0,000004% / 1,000,000-ний 4/ хувь түдгэлзсэн байна.

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

6. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа 100 хувь буюу 45,310,870 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Чулууны Энхболд	11.11%	45,310,868
2	Амарсанаагийн Бат-Орших	11.11%	45,310,868
3	Энхболдын Батболд	11.11%	45,310,868
4	Эрдэнэбаатарын Ариунтуяа	11.11%	45,310,868
5	Энхболдын Уянга	11.11%	45,310,868
6	Амарсанаагийн Гэрэлцогт	11.11%	45,310,868

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Жаргалсайханы Энхтулга	11.11%	45,310,866
2	Шатарын Мөнхбаатар	11.11%	45,310,868
3	Чулуунбаатарын Оргил	11.11%	45,310,868

тус тус санал авч эдгээр гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов. За тооллогын комиссын шийдвэр тогтоолыг уншиж танилцуулж дууслаа.

Хэлэлцэх асуудал болон санал хураалттай холбоотой ямар нэгэн санал гомдол гараагүй тул 11:05 цагт хурлыг хаав.

Хурлын дарга:

Э.Батболд /

Хурлын тэмдэглэл хөтөлсөн

С.Ганбат /

